



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН
ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА**
/ЭЦСИЙН ТАЙЛАН/

ТАЙЛАНГИЙН ТОЙМ

Салбарын хөгжлийн бодлогын хүрээнд урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн үнэлгээг боловсруулсаны үндсэн дээр бодлого төлөвлөлтийн боломжит хувилбаруудыг тогтоож, түүнд үндэслэн тодорхойлсон Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийн бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого”-д тусгах уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бодлогын зөвлөмжүүд

Н.Даваасамбуу

МУ-ын Зөвлөх инженер, доктор (Ph.D)

АГУУЛГА

Өмнөтгөл	2
Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эдийн засаг, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл	3
Уул уурхайн салбарын үйл ажиллагаа байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл	7
Ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн чиг хандлага	9
Зарим гадаад орнуудын эрдсийн баялгаа ашиглаж буй туршлага	15
Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг бүсчлэн хөгжүүлэх бодлогын үндэслэл	18
Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын бүсүүд	19
Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын нийлүүлэлт, орц, гарцын сүлжээ	30
Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил байршлын нэмүү өртгийн сүлжээ	40
Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг бүсчлэн хөгжүүлэх бодлогын зөвлөмж	46
Дүгнэлт	52
Ашигласан материалын жагсаалт	54

Өмнөтгөл

Энэхүү судалгааны дунд шатанд Монгол улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын нөхцөл байдлын судалгааг хийж гүйцэтгэсэн. Уг судалгаагаар манай улсын нутаг дэвсгэр дээр одоо ажиллаж байгаа металл ба металл бус ашигт малтмалын уурхай, нөөц нь тогтоогдсон нүүрсний орд, уурхайнууд, мөн газрын тосны хайгуулын талбай, уурхай, цацраг идэвхит ашигт малтмалын хайгуулын талбай, ашигт малтмалын стратегийн болон стратегийн нөөц ордуудын байршил зэргийг тус тусад нь газрын зураг дээр байршуулан тэдгээрийн тархалт, үйл ажиллагааны талбайн хүрээг тоймлон үзүүлсэн билээ. Мөн салбарын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн үр дагаварыг тус бүрт нь тодорхойлсон нь салбарын үйл ажиллагаа эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг боловсруулах үндэслэл болсон. Өмнөх шатанд тус тусад нь газрын зураг дээр байршуулсан орд, уурхайнууд, хайгуулын талбайн байршлыг нэг зураг дээр байршуулснаар уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын бүсүүдийг төсөөлөх боломжийг бий болгосон. Ийнхүү тогтоосон салбарын хөгжил, байршлын бүсүүдээс гарах бүтээгдэхүүний төрлийг тогтоож нийлүүлэлт, орц, гарцын сүлжээний төсөөллийг урьдчилан гаргаж, тээвэр-логистикийн үйл ажиллагааны тойм, чиглэлийг тогтоолоо. Тэрчлэн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн чиглэл, схемийг бүс тус бүрийн нутаг дэвсгэрийг хамрах хэмжээнд гаргаж, холбогдох зургийг үйлдсэн болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх бодлогын зөвлөмжийг 7 чиглэлээр боловсруулан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлогод тусгуулахаар санал болгож байна.

Судалгааны ажлын явцад уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын бүсчлэлийн санал болгож буй хувилбарыг харуулсан зураг, салбарын үйл ажиллагааны нийлүүлэлт, орц, гарцын тойм зураг, мөн салбарын нэмүү өртгийн сүлжээний схем зураглал зэргийг боловсруулан энэхүү эцсийн хугацааны тайланд оруулав.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил,
байршлын судалгааны зөвлөх
Н.Даваасамбуу, доктор (Ph.D)

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эдийн засаг, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл

Байгалийн болон эрдсийн баялаг элбэгтэй улс орнуудын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг байнга татаж байдаг бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр уул уурхайн олборлох үйлдвэрийн тоо нэмэгдэж, үйлдвэрлэл нь өсөж, тухайн улс орны орлогыг нэмэгдүүлдэг.

Энэ нь тухайн улс орны эдийн засаг, нийгэмд ойрын болон дунд хугацаанд эерэг, урт хугацаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх явдал байдаг. Уул уурхайгаас шалтгаалан өссөн орлогыг буруу хуваарилаж, буруу зарцуулснаас ийм байдалд хүрдэг бол уг орлогыг алсын хараатай зөв хуваарилан зохицуулж, хуримтлал үүсгэх, түүнийгээ гадаад, дотоодын үр ашигтай хөрөнгө оруулалтад ашиглах замаар зөв ухаалаг зарцуулбал эдийн засгийн байнгын өсөлт хөгжилтөнд хүргэх тулгуур, гүүр нь болдог ажээ.

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээнд нөлөөлөх нь:

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл үндэсний орлогоо нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангахад чухал нөлөө үзүүлдэг. 2018 оны эхний 7 сарын байдлаар манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) үйлдвэрлэлийн үнийн дүн 15166.6 их наяд төгрөг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үнийн дүн 10034.4 их наяд төгрөг байгаа бол уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үнийн дүн 6972.8 их наяд төгрөг болж, ДНБ-нд уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь 23.79%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд эзлэх хувь 69.49% байна.

Гадаад худалдааны тэнцэлд нөлөөлөх нь:

Уул уурхайн салбар 2018 оны эхний 7 сарын байдлаар 5296850.3 мянган ам. долларын бүтээгдэхүүн экспортлож, нийт экспортын 94%-ийг эзэлж байгаа бол уул уурхайн салбарын үйлдвэрлэлд шаардлагатай машин, тоног төхөөрөмж, сэлбэг, материал, газрын тосны бүтээгдэхүүн гэх мэт нь улсын нийт импортын хэмжээнд нэлээд жин дарж байна.

Манай улсын гадаад худалдааны тэнцэл 2013-2016 онд 4 жил дараалан алдагдалтай гарч байсан бол 2017 оноос дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ ханш өсч, мөн Монгол улсын нүүрсний биет экспортын хэмжээ өссөнөөр 2017 оны дунд үеэс ашигтай гарч эхэлсэн. Өнгөрсөн оны эцсийн байдлаар буюу

12-р сард нийт 1,459.9 сая ам.долларын ашигтай төлбөрийн тэнцэл гарсан байна.

Улсын төсөв санхүүд нөлөөлөх нь:

Монгол улсын төсвийн нийт орлогыг 2018 онд 7,862.8 тэрбум төгрөгөөр төлөвлөж байгаагаас 1,720.0 тэрбум төгрөг буюу 21.9%-ийг нь уул уурхайн салбараас орохоор, тогтворжуулалтын санд 122.8 тэрбум, ирээдүйн өв санд 508.7 тэрбум төгрөг хуримтлуулахаар тус тус төлөвлөсөн байна.

Уул уурхайн салбараас улсын төсөвт төвлөрөх татвар, хураамж, төлбөр дээрх 21.9%-ийг бүрдүүлж байгаа юм.

Улсын нэгдсэн төсөвт:

- Улсын төсвөөр хийгдсэн хайгуулын ажлын нөхөн төлбөр;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
- Агаарын бохирдлын төлбөр;
- Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр;
- Тээврийн хэрэгслийн татвар;
- Ус ашигласны төлбөр;
- Газар ашигласны төлбөр;
- Импортын барааны албан татвар;
- Нэмэгдсэн өртгийн албан татвар;
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар;
- Хүн амын орлогын албан татвар;
- Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгал.

Орон нутгийн хөгжлийн санд хуваарилах татвар, хураамж, төлбөр

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 5%;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн 50%;
- Газрын тосны хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийн 30% (аймгийн санд 20%, сумын санд 10%);
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%;
- Дотоодын бараа , үйлчилгээний НӨАТ-ын 10%;
- Мега төслийн орлогын 30% (аймаг тус бүрийн Орон нутгийн хөгжлийн санд)

- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн 50% (аймаг тус бүрийн Орон нутгийн хөгжлийн санд).

Эдийн засгийн салбарын бүтцэд үзүүлэх нөлөөлөл:

Уул уурхайн салбар нь ДНБ-ний 23.8%, экспортын 90%-ийг бүрдүүлж байгаагаас гадна энэ салбарт ажиллагсадын тоо 2004 оноос хойш 3 дахин өсөж, аж үйлдвэрийн салбарын ажиллагсадын 25% -ийг эзэлж, цалин хөлс, урамшууллын хэмжээ бусад салбаруудтай харьцуулбал 2 дахин их байна. Олборлох салбар өргөжин хөгжихийн хэрээр түүнийг дагаад хангамж, үйлчилгээний салбаруудад ажлын байр олноороо бий болж байна. Өөрөөр хэлбэл уул уурхай нь хангамж, үйлчилгээний үндэсний компаниудын хувьд хөрөнгө оруулагч, ажил олгогч, кластер бүрдүүлэгч болон хувирч байгаа юм. Энэ агуулгаараа уул уурхай нь төвлөрлийг сааруулахад бодитой нөлөөлөл үзүүлэгч хүчин зүйл болсоор байгаа бөгөөд гагцхүү үүнийг төрийн бодлого, зохицуулалтаар зөв чиглүүлж, ашиглах шаардлага тулгарч байгаа юм.

Хэрэглээний үнэ, төгрөгийн ханшид нөлөөлөл нь:

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогын өсөлтийн нөлөөллөөс шалтгаалан нэмэгдэж буй төсвийн орлогыг зөв, буруу зарцуулснаас шалтгаалан хэрэглээний үнэ, инфляцид эерэг, сөргөөр нөлөөлөл хамаарлууд бий болдог. Өссөн орлогыг болзошгүй эрсдэлээс хамгаалах сан болон ирээдүйн хөрөнгө оруулалтын санд хуримтлуулан хадгалах нь эерэг, цалин хөлс, нийгмийн халамж, төр, засгийн зардлыг нэмэгдүүлэх чиглэлд зарцуулах нь сөрөг нөлөөллийг бий болгодог.

Хүн амын амьжиргаанд нөлөөлөл нь:

Монгол улсын үндэсний статистикийн хорооноос гаргасан 2018 оны эхний 7 сарын Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал товхимолд уул уурхайн олборлох салбарт 23.8 мянган хүн ажиллаж байна гэсэн нь энэхүү бодлогын судалгааны нөхцөл байдлын судалгааны явцад тогтоосон тоотой үндсэндээ таарч байгаа юм. Уул уурхайн салбарт ажиллагсадын орлого, цалин хөлсний хэмжээ бусад салбарынханаас 2 дахин их байдаг нь 23.0 мянга гаруй өрхөд буюу ойролцоогоор 120 орчим мянган хүний амьдралд шууд нөлөөлдөг гэж хэлж болно. Үүнээс гадна уул уурхайн орлого нэмэгдсэнээс хүүхдийн мөнгө болон нийгмийн даатгал, халамжийн санд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд

нөлөөлж эдгээр сангаас хувь хүртдэг иргэдийн амьдралд шууд бусаар нөлөөлж байдаг байна.

Эдийн засаг, нийгмийн бусад салбаруудад нөлөөлөх нь:

Уул уурхайн үйлдвэрлэл нь одоогийн байдлаар бусад салбаруудын үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна. Уул уурхайн үйлдвэрлэл нь барилга, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл, холбоо, цахилгаан, уур, ус зэрэг дэд бүтцийн салбаруудын үйлдвэрлэлд эерэг шугаман хамааралтай байгаа нь уул уурхайн үйлдвэрлэл хөгжихөд дэд бүтцийн салбарууд дагаад хөгждөг болохыг харуулж байгаа юм. Боловсруулах үйлдвэрийн салбарын үйл ажиллагаатай эерэг шугаман хамааралтай бол боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбартай шугаман хамаарал багатай байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх тухайд:

Байгалийн нөөц баялаг нь эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц өгч, түшиг тулгуур болдог гэдэгтэй маргах хүн үгүй бизээ. Гэхдээ энэхүү эерэг нөлөөлөл нь байгалийн баялгийн их бага хэмжээнээс бус түүнийг хэрхэн зүй зохистой, зөв ашиглаж байгаа болон түүний үр өгөөжийг оновчтой, алсын хараатай, үр ашигтай хуваарилаж байна вэ гэдгээс хамаарна.

Байгалийн нөөц баялаг ихтэй боловч түүнийгээ буруу ашиглаж, буруу зарцуулбал “Голланд өвчин”, “Баялгийн хараал” мэтэд өртөж, хөгжих нь бүү хэл доройтдог тухай ойлголт, гашуун туршлагууд ч бий.

Эдгээр өвчин, хараал гэгдэх сөрөг нөлөөллүүд нь байгалийн баялгийнхаа экспортод түшиглэж, түүнийг шүтэх хандлагаас үүдэн бий болдог аж. Байгалийн баялаг ялангуяа эрдэс баялгийн экспорт нь **нэгдүгээрт**: тухайн орны экспортын бусад салбарт сөргөөр нөлөөлж, өрсөлдөх чадварыг нь бууруулж, яваандаа уналтанд оруулдаг, **хоёрдугаарт**: эрдэс баялгийн түүхий эдийн үнэ байнга буурах, хэлбэлзэх хандлагыг агуулж байдаг, энэ нь үнийн өсөлтийг, хязгаарлах, бууруулах банк, санхүүгийн олон нарийн арга, хөшүүрэг үйлчилж байдагтай холбоотой, эрдэс баялгийн экспортын үнийн бууралт, хэлбэлзлийг дагаад бусад салбаруудын төлөвлөлт, төсөөлөлд хэлбэлзэл үүсэж, хямрал бий болж, эдийн засаг нь бүхэлдээ тогтворгүйждэг, ер нь нэмүү өртөг шингэсэн

эцсийн бүтээгдэхүүний үнэтэй харьцуулахад эрдэс баялгийн түүхий эдийн үнэ буурах, хэлбэлзэх нь их байдаг, **зуравдугаарт**: засгийн газрын зардал нэмэгдэх, бэлэнчлэх сэтгэлгээнд автах, ирээдүй муутай, түр зуур үр ашигтай мэт харагдах төсөл санхүүжүүлэх, эдийн засгийг удирдах, бодлого боловсруулах чадвар нь муудах, авилгад автах гэх мэтээр төр, засгийн чанар, чадавхи нь сулардаг байна, **дөрөвдүгээрт**: байгаль орчныг доройтуулдаг, энэ нь хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг салбарын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг, **тавдугаарт**: уул уурхайг хэт түшиглэснээс шалтгаалан хөгжлийн гол хөдөлгүүр болсон боловсрол, мэдлэг, ур чадвар зэрэг зэрэг хүний үнэлэмжүүд буурдаг, **зургаадугаарт**: уул уурхайг дагаад зарим боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрүүд бий болох хэдий ч бусад хүнд хөнгөн аж үйлдвэр, өндөр технологийн салбар зэрэг хөгжиж, эдийн засгаа төрөлжүүлэх боломж хомс байдаг байна. Энэ бүгд нь “Голланд өвчин”-ий илрэлүүд бөгөөд эдгээр нь ужгирсаар улс орны хөгжил удаашран доройтож, ДНБ-ний өсөлт буурч, “баялгийн хараал”-д хүргэдэг ажээ. Экспортыг чухалчлах хандлага манай улсад ч одоогоор хүчтэй оршсоор байна. Ашигт малтмалын үйлдвэрлэл эрхлэх бүрийдээ “экспортыг нэмэгдүүлнэ, ингэснээр улс орны эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулна” гэсэн уриа, лоозонг урдаа барьцгаадаг маань ч нууц биш. Гэхдээ үүнийг юу юугүй буруутгах нь зүйд үл нийцнэ. Хөгжлийн эхний үе шатуудад экспортыг чухалчлах нь бараг гарцаагүй зүйл.

Экспорт бол олон улсын эдийн засгийн харилцааны чухал хэрэглүүр мөн боловч ямагт тогтвортой, өндөр үр ашигтай, харилцагч буюу хэрэглэгч нь байнгын байх нөхцөлүүд нь тогтмол, удаан хугацаагаар хадгалагддаггүй. Иймээс аливаа экспортын үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэхдээ дэлхий нийтийн эрэлт, нийлүүлэлт, үнэ, гол үйлдвэрлэгч, хэрэглэгч, нийлүүлэлтийн сүлжээ зэргийг харгалзан сайтар судалж, тооцоолсон, уян хатан бодлого боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх шаардлагатай. Уул уурхайн үйлдвэрлэл нь нэлээд их хөрөнгө санхүү, хүч далайц шаарддагтай адил улс орон уул уурхайд тулгуурлан хөгжил дэвшлийн гараан дээр гаръя гэвэл мөн л эрчтэй тууштай бодлого, эрчимтэй өргөн үйл ажиллагаа өрнүүлэхийг шаардана.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа нь геологи хайгуулын ажлын шатнаас эхлээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж эхэлдэг ба ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын явцад сөрөг нөлөөллийн хэмжээ нэмэгддэг. Эдгээр сөрөг нөлөөллийг орчин бүрээр нь авч үзвэл:

Агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад өрөмдлөг, хайгуулын зориулалттай уулын ажил, уурхайн хөрс хуулалт, олборлолт, овоолгын ажлууд, далд уурхайн нэвтрэлтийн ажлууд, технологийн тээвэрлэлт, гадаад дотоод тээвэр, логистик, үйлчилгээний ажлууд гээд маш олон тооны техник, тоног төхөөрөмжийн хүчээр хийгддэг ажлуудын явцад техникийн утаа, тэдгээрийн хөдөлгөөнөөс шалтгаалан үүсэх тоос зэрэг нь орчны агаар мандалыг бохирдуулдаг. Бохирдсон агаар нь тухайн орчинд ажиллаж, амьдарч буй иргэд, мал амьтны амьсгал, эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна салхины аясаар зөөгдөж, бэлчээр ургамал, усны эх үүсвэр зэрэгт ч нөлөөлж байдаг.

Дуу чимээ, чичиргээний нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэл, төслийн талбайд ажиллаж байгаа машин, тоног төхөөрөмжийн үүсгэж байгаа элдэв янзын дуу чимээ болон уурхайн олборлолтын явцад хийгддэг өрөмдлөг, тэсэлгээний ажлаас их бага хэмжээний чичиргээ, доргион үүсэх нь хүн, амьтны сонсгол хийгээд амгалан тайван байдал, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүсгэдэг.

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад газрын гадаргуугийн болон газрын гүний усны нөөц, түүний урсац хэсгүүд өртөх тохиодол байнга гардаг бөгөөд энэ нь усны нөөцөд их бага хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлдэгээс гадна уул уурхайн ашиглалт, боловсруулалтын технологийн хэрэгцээнд багагүй хэмжээний ус зарцуулагддаг нь усны нөөцийг багасгах, бохирдуулах сөрөг нөлөөллийг үзүүлдэг.

Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэл нь дэлхийн чулуулаг бүрхүүл, газрын хэвлийтэй харьцдаг үйлдвэрлэл учраас чулуулаг бүрхүүлийг хучиж буй хөрс, ургамалыг гэмтээх замаар шууд сөргөөр нөлөөлдөг. Мөн их, бага хэмжээний уурхайн ухшуудыг үүсгэхээс гадна тодорхой хэмжээний талбайг хөрсний болон хаягдал чулуулгийн овоолгоор дарж, ашиглалтгүй болгох нөлөөлөл ч байдаг.

Биологийн төрөл зүйлүүдэд үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд биологийн зарим нэг төрөл зүйлүүд өртөх нь цөөн биш байна. Үүнд ургамал, ойн талбай хөндөгдөх, зарим амьтдын амьрах орчин хязгаарлагдах, оршин буй газраасаа нүүдэллэх, дайжих зэргээр сөрөг нөлөөлөлд өртдөг.

Хог, хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны явцад ахуйн төрөл бүрийн хог хаягдлаас гадна техник, технологийн гаралтай хог хаягдал их хэмжээгээр гарч байгаль орчин, газар нутгийг бохирдуулдаг. Үүнд цаас, даавуу, хуванцар, төмөр, модны, хоолны хаягдал, элдэв химийн бодис, шатах тослох материалын хаягдал, асгаралтаас гадна аккумулятор, резин дугуй, бусад резин эдлэл зэрэг багтана.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хийгдэж буй байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа

Дээр дурьдсан сөрөг нөлөөллийг бууруулах багасгах талаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны нөхөн сэргээлийн төлөвлөгөө, биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн зохион байгуулалт, төлөвлөгөө, уурхайн хаалтын төлөвлөгөө зэрэг маш олон тооны бичиг баримт, стандартуудыг боловсруулан мөрдөхийн дээр олон тооны зааварчлагаа, урьдчилан сэргийлэх санамжуудыг үйл ажиллагаандаа хэрэглэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, аль болох бага

нөлөөлөлтэй болгох талаар идэвхитэй, тодорхой ажиллаж байгаагийн дээр байгаль орчны хяналт, мониторингийн олон төрлийн ажил, шинжилгээнүүдийг тогтмолжуулан ажиллаж, олон улсын туршлага, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн чиг хандлага

Сүүлийн 10 жилийн хугацаанд нүүрс, уранаас бусад эрдэс баялгийн эрэлт жил бүр 2-4%-иар өсөж ирсэн ба 2020 хүртэл энэ хэмжээгээрээ өсөх хандлагатай байна. Үүнд БНХАУ-ын оролцоо, нөлөөлөл их болж, 2020 онд Хятадын ашигт малтмалын эрэлт 4.1%-иар өснө гэж судлаачид үзжээ. Энэ нь БНХАУ 2020 онд дэлхийн ашигт малтмалын нийт хэрэглээний 42%-ийг эзлэнэ гэсэн үг юм.

Голлох ашигт малтмалын дэлхийн зах зээл дээрх эрэлт

Хүснэгт 1.

Ашигт малтмал	Нүүрс, сая.тн	Уран, тн	Төмөр, сая тн	Зэс, мян.тн	Цайр, мян.тн	Никель, мян.тн
2004	776	67,320	1,186	17,010	10,292	1,279
2013	1,326	64,978	1,969	20,666	13,295	1,823
2020	3,3	2,8	1,9	3,1	4,3	2,9

БНХАУ-ын гол ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлт

Хүснэгт 2.

Ашигт малтмал	Нүүрс, сая.тн	Уран, тн	Төмөр, сая тн	Зэс, мян.тн	Цайр, мян.тн	Никель, мян.тн
2004	18.6	1,260	399	3,565	2,217	173
2013	321	6,711	1,154	9,165	6,063	973
2020	541	6,450	1,328	12,926	9,854	1,189

Эх сурвалж: Wood Mackenzie, AME, WNA

2000-аад оны дунд үеэс огцом өсөх болсон эрдсийн баялгийн нийлүүлэлт болон үнийн хэлбэлзэл нь дэлхийн зах зээл дээрх өрсөлдөөнийг идэвхижүүлсэн. Хятад, Австрали, Төв болон Өмнөд Америкийн байгалийн баялаг ихтэй орнууд ашиг орлогоо нэмэгдүүлэхийн төлөө янз бүрийн арга замыг эрэлхийлж байна. Тухайлбал зарим улс орнууд эрдэс баялгийн боловсруулаагүй бүтээгдэхүүнийг экспортлохгүй байх бодлого баримтлаж байхад дэлхийн уул уурхайн томоохон компаниуд өөр хоорондоо нэгдэж, нэмүү өртгийн гинжин хэлхээ, их хэмжээний хөрөнгө оруулалт зэрэг хэлбэрээр зах зээлээ өргөжүүлэх, монопольлол тогтоох бодлого хэрэгжүүлж байна. Ийнхүү монопольлол тогтоосноороо эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, үнийн хэлбэлзэл үүсгэх зэрэг үйлдлүүдийг хийж байна. Зарим төрлийн эрдсийн бүтээгдэхүүний

дэлхийн хэмжээний нийлүүлэлт, зах зээлийн 40-85%-ийг эзэлдэг том компаниудын нэгдэл хоршил байдаг байна.

Ашигт малтмалын эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр эрэлт ихтэй ашигт малтмалын нөөц хомсдож, чанар нь буурах, өөрийн өртөг нь нэмэгдэх хандлага бий болж байгаагийн дээр нөөц, олборлолтын харьцаа жилээс жилд багасах төлөвтэй байна.

Монгол улсын хувьд 80 гаруй төрлийн ашигт малтмалын 6000 гаруй орд, илрэлтэй гэгддэг бөгөөд дэлхийд баялгаараа 7 дугаарт жагсдаг. Нүүрс, зэс, молибден, алт, мөнгө, цайр, вольфрам, уран, болор зэрэг ашигт малтмал арвинтайд тооцогддог.

Монгол улсын гол нэрийн эрдсийн баялгийн нөөц

Хүснэгт 3.

Эрдэс баялаг	Нэгж	Монгол	Дэлхий	Эзлэх хувь	Дэлхийд эзлэх байр
Нүүрс	Тэрбум.тн	98	8,610	1.1	10
Хайлуур жонш	Сая.тн	22	240	9.2	4
Молибден	Мян.тн	160	11,000	1.5	7
Уран	Мян.тн	56	5,327	1.0	Мэдээлэлгүй
Зэс	Сая.тн	23	550	4.2	Мэдээлэлгүй
Төмрийн хүдэр	Сая.тн	453	150,000	0.3	Мэдээлэлгүй
Хар тугалга-цайр	Сая.тн	3	79	3.8	Мэдээлэлгүй
Гянтболд	Мян.тн	70	3,000	2.3	Мэдээлэлгүй
Алт	тн	763	47,000	1.6	Мэдээлэлгүй

Эх сурвалж: АНУ Газарзүйн судалгаа 2015

БНХАУ-ын эрдсийн баялгийн зах зээлийн төлөв байдал

Хятад улс ашигт малтмалын нөөц арвинтай. Ялангуяа хөнгөн цагаан, сурьма, барит, висмут, нүүрс, хайлуур жонш, алт, төмөр, молибден, газрын ховор элемент, цагаан тугалга зэрэг бүх төрлийн ашигт малтмалыг олборлож байна. Мөн сурьма, барит, хайлуур жонш, графит, индий, газрын ховор элементүүд болон гянтболд экспортлогч гол орон юм. Хром, кобальт, зэс, төмрийн хүдэр, манган, никель, цагаан алтны эрэлт хэрэгцээг үндэсний үйлдвэрлэлээрээ хангадаг. Харин ашигт малтмалын нийт хэрэгцээнийхээ 40%-ийг импортоор авдаг, нийт гадаад худалдааны нь 25%-ийг ашигт малтмалын бүтээгдэхүүн

эзэлдэг. Хятадын эрдэс баялгийн зах зээл дэлхийн түүхий эдийн зах зээлд томоохон байр суурийг эзэлдэг.

БНХАУ-ын голлох ашигт малтмалын нөөц

Хүснэгт 4.

Ашигт малтмал	Нэгж	Хятад (А)	Дэлхий (В)	Зэрэглэл
Вольфрам	тн	1,900,000	3,500,000	1
Сурьма	тн	950,000	1,800,000	1
Барийн сульфат	Мян.тн	100,000	350,000	1
Цайр	Мян.тн	43,000	250,000	2
Ванади	Мян.тн	5,100	14,000	1
Молибден	Мян.тн	4,300	11,000	1
Тугалга	Тн	1,500,000	4,700,000	1
Газрын ховор элемент	Тн	56,000,000	140,000,000	1
Алт	Тн	1,900	54,000	8
Кадмий	Тн	9,200	500,000	1
Висмут	Тн	240,000	320,000	1
Мөнгө	Тн	43,000	520,000	5
Графит	Мян.тн	55,000	130,000	2
Хар тугалга	Мян.тн	14,000	89,000	2
Кобальт	Тн	80,000	7,200,000	9
Төмрийн хүдэр (металл)	Сая.тн	7,200	81,000	4
Бор	Мян.тн	32,000	210,000	4
Марганц	Мян.тн	44,000	630,000	6
Литий	тн	3,500,000	13,000,000	4
Хөнгөн цагааны хүдэр	Мян.тн	830,000	28,000,000	8
Хайлуур жонш	Мян.тн	24,000	240,000	4
Зэс	Мян.тн	30,000	690,000	6
Магнийн нэгдэл	Мян.тн	500,000	2,400,000	2
Мөнгөн ус	Тн	21,000	94,000	3
Фосфор	Мян.тн	3,700,000	67,000,000	2
Калийн карбонат	Мян.тн	210,000	6,000,000	5
Титан	Мян.тн	200,000	700,000	1
Иттрий	Тн	220,000	540,000	1
Циркони	Мян.тн	500	67,000	5
Никель	Тн	3,000,000	74,000,000	7
Нүүрс	Сая.тн	114,500	891,531	3

Эх сурвалж: USGS, Ашигт малтмалын бүтээгдэхүүний тойм 2014

Хятадын эдийн засаг ойрын ирээдүйд буурах хандлагатай байгаа ба төр, засаг нь ч энэ байдлыг хүлээн зөвшөөрч байна. Үүнээс үзэхэд эдийн засгийн өсөлт нь дунджаар 7% байна. Хэрэв АНУ-ын эдийн засаг сэргэж газрын тосны үнэ бага хэвээр байвал Хятадад экспортын илүү боломж гарч, эдийн засаг нь сэргэх боломж гарч болох юм. Ямартаа ч ойрын жилүүдэд Хятад дэлхийн зах зээл дээр томоохон худалдан авагч хэвээр байх төлөвтэй байна.

ОХУ-ын эрдсийн баялгийн зах зээлийн төлөв

ОХУ-ын газрын тос, байгалийн хийн салбар нь ДНБ-ний 1/5, экспортын 2/3, төсвийн орлогын 1/2-ийг эзэлдэг байна. Газрын тосны үнэ бууралттай байгаа үед мөнгөний ханш болон зээлжих зэрэглэл нь буурч, мөнгөний эргэлт багасаж, санхүүгийн зах зээл таагүй болж ирдэг.

ОХУ-ын эрчим хүчний ашигт малтмалын нөөц

Хүснэгт 5.

Ашигт малтмал	Нэгж	ОХУ	Дэлхий	Эзлэх хувь
Газрын тос	Тэрбум баррель	93.0	1,687.9	5.5
Байгалийн хий	1 триллион м2	31.3	185.7	16.8
Нүүрс	Сая.тн	157,010	891,531	17.6

Эх сурвалж: BP World Energy 2014

Сүүлийн үед газрын тосны үнэ өсөх хандлагатай болж байгаа хэдий ч эрдэс баялгийн бүтээгдэхүүн импортлон авах нөхцөл байдал тааруу байсаар байна.

БНСУ-ын эрдэс баялгийн хэрэглээний төлөв

БНСУ-ын эдийн засгийн 51% нь автомашин, усан онгоц, гангийн үйлдвэрлэл, цахилгаан эрчим хүч, электроникийн болон бусад аж үйлдвэрийн салбарт тулгуурладаг тул эдгээр нь эрдэс баялгийн түүхий эдээс ихээхэн хамааралтай. Коксжих нүүрс, төмөр, зэс зэрэг голлох төрлийн эрчим хүч, аж үйлдвэрийн түүхий эдийн хэрэглээгээрээ дэлхийд 5-рт ордог.

БНСУ-ын эрдэс баялгийн хэрэглээний өнөөгийн байдал

Хүснэгт 6.

Ашигт малтмал	Нүүрс	Уран	Төмрийн хүдэр	Зэс	Цайр	Никель
Хэрэглээ (дэлхийн зэрэглэл)	123 сая тн (7)	4,100 тн (5)	74 сая тн (5)	946,000тн (5)	1,044,000 тн (3)	128,000 тн (4)

Эх сурвалж: Wood Mackensie

Аж үйлдвэрийн салбарын хөгжлөөс үүдэн ашигт малтмалын импортын хэмжээ нэмэгдсээр байна. Ашигт малтмалын импортоос хараат байдал нь 2000 онд

84% байсан бол 2012 онд 95% болжээ. Ашигт малтмалын хэрэгцээнийхээ 99.1%-ийг импортоор авдаг.

БНСУ нь ашигт малтмалын хэрэгцээгээ тогтвортой хангахын тулд Австрали, Чили, Индонез зэрэг улсуудтай гадаад худалдаа хийхээс гадна ОХУ, БНХАУ-тай хамтран ажиллаж байна.

Япон улсын эрдсийн баялгийн хэрэглээний төлөв

Японд доломит, шохойн чулуу, цахиур зэрэг металл ашигт малтмал элбэг байдаг. Гангийн болон автомашины үйлдвэрлэлд шаардлагатай төмөр, зэс, хар тугалга, цайр, мөнгө, бусад металлын түүхий эд болон бүтээгдэхүүнийг импортоор авдаг, зүүн азийн эрдэс баялгийн гол хэрэглэгч орон юм.

Японы эрдэс баялгийн хэрэглээний жишиг

Хүснэгт 7.

Төрөл зүйл	Нэгж	2009	2010	2011	2012	2013	2014
Боловсруулсан хөнгөн цагаан	Мян.тн	1,522.9	2,025.0	1,945.8	1,981.6	1,771.8	2,003.7
Боловсруулсан кадмий	тн	2,002.1	2,045.5	1,734.5	1,840.8	1,896.0	1,897.1
Боловсруулсан зэс	Мян.тн	875.4	1,060.3	1,003.3	985	994.3	1,085.2
Боловсруулсан хар тугалга	Мян.тн	189.6	223.8	236	273	253.9	254.5
Боловсруулсан никель	Мян.тн	147.6	177	173.6	159.3	158.7	161.1
Боловсруулсан тугалга	Мян.тн	23	35.7	26.9	27.7	28.3	27.1
Цайр хавтан	Мян.тн	433.1	516.2	500.6	479.1	479.7	503.5

Эх сурвалж: Дэлхийн металлын статистикийн жилийн тайлан -2014

Японы ашигт малтмалын хэрэглээ нь өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Монголын ашигт малтмал олборлолтын хэтийн төлөв

Монголд ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл 1655-ыг аж ахуйн нэгжүүдэд олгосон ба эдгээрээс 2018 оны эхний 7 сарын байдлаар идэвхитэй үйл ажиллагаа эрхлэж байгаа 285 компани байгаа юм. Энэ тоо цаашид нэмэгдэх ба үүнийг дагаад гол нэр төрлийн ашигт малтмалын олборлолтын хэмжээ өсөх магадлал өндөр юм. Ийнхүү зах зээлийн хэрэглээ болон

олборлолтын хэмжээ өсөх төлөв байдлууд давхцаж байгаа нь улсын эдийн засгийн өсөлтийн таатай нөхцөл бүрдэх найдвар төрүүлж байна.

Монголын ашигт малтмал олборлолтын хэтийн төлөв

Хүснэгт 8.

Ашигт малтмал	Нэгж	2018	2020	2025	2030	2032
Нүүрс	сая тн	57.5	74.0	101.8	122.8	131.4
- Экспорт	сая тн	43.0	55.0	74.4	89.0	94.9
- Э.хүчний эрэлт	сая тн	11.7	15.0	21.8	27.1	29.3
- Орон нутаг	сая тн	0.8	0.9	1.0	1.0	1.1
- Бусад	саятн	2.0	3.1	4.6	5.7	6.1
Зэсийн баяжмал	сая тн	1.3	3.2	5.6	7.6	8.3
Зэс металл	мян тн	2.6	2.6	2.6	2.6	2.6
Молибдений баяжмал	мян тн	5.8	5.5	6.2	6.6	6.8
Алт	тн	19.0	24.0	34.0	39.0	40.8
Төмрийн хүдэр	сая тн	10.0	10.0	11.0	12.0	12.0
Хайлуур жонш	мян тн	120.0	200.0	200.0	200.0	200.0
Вольфрамын баяжмал	тн	150.0	150.0	150.0	150.0	150.0
Цайрын баяжмал	мян тн	95.8	90.5	84.6	80.0	78.0

Эх сурвалж: Монголын Уул уурхайн яам

Зарим гадаад орнуудын эрдсийн баялгаа ашиглаж буй туршлага

Олон улсын туршлагаас харахад байгалийн баялгаа зөв зүйтэй ашиглаж эдийн засгаа хөгжүүлсэн улс орнууд цөөнгүй байдаг. Тэдгээрийн туршлагыг судлах нь сөрөг нөлөөлөл, үзэгдлээс зайлсхийх, эдийн засгаа зөв хөгжүүлэхэд тустай. Африкийн Ботсвана, Зүүн Өмнөд Азийн Индонези, Малайзи, Тайланд Хойд Америкийн Канад, Өмнөд Америкийн Чили, Австрали, Норвеги, Шинэ Зеланд зэрэг улсууд эрдэс баялгаа зөв ашиглан хөгжсөн байна. Эдгээр улсууд байгалийн баялгийн орлогоо ирээдүйн хөрөнгө оруулалтын зорилгоор хуримтлуулж, зарим хэсгийг нь эрсдэл багатай, өндөр ашигтайгаар гадаад улсуудад хөрөнгө оруулж, тодорхой хувийг нь стратегийн салбаруудаа дэмжихэд зарцуулж иржээ. Мөн хөгжлийн урт хугацааны бодлого, стратеги боловсруулж, бусад салбарын бодлоготой уялдуулсан байна.

Норвеги

Нэг хүнд ногдох газрын тосны экспортоор Саудын Арабын дараа ордог. 1975 онд Хойд тэнгисээс газрын тос олборлож эхлэнгүүт тусгай хуримтлалын сан байгуулж, жилд тус сангийн дөрөвхөн хувийг зарцуулж ирсэн. 2011 он гэхэд тусгай сандаа 550 тэрбум ам.доллар хуримтлуулсан байжээ. Төр нь уул

уурхайн салбарт давуу эрхтэйгээр оролцдог. Уул уурхайн салбарын бодлого, эрх зүй, татварын орчин, стандартыг сайжруулан ажилласан байна. Мөн үндэсний хөгжлийн бодлогоо сайтар боловсруулж, уул уурхайн салбарын бодлогыг түүнтэй нягт уялдуулан хэрэглэж чадсан ажээ.

Малайзи, Индонези, Тайланд

Эдгээр нь Азийн “бар” улсууд юм. Малайз нь шингэрүүлсэн хийн дэлхийн гол нийлүүлэгч. Мөн нүүрс, байгалийн хий, дал модны тос, байгалийн каучукийн дэлхийн гол гурван экспортлогчийн нэг. Тайланд улс мөн каучукийн гол нийлүүлэгчийн нэг юм. Энэ улсуудад эдийн засаг дахь төрийн зохицуулалт нь өндөр, төвлөрсөн бодлого, удирдлагатай, стратегийн бараа үйлчилгээний үнийг төрөөс тогтоодог. Үйлдвэржих бодлогыг хүчтэй хэрэгжүүлж байгаа. Тайланд улс гэхэд 2015 онд дэлхийн машин үйлдвэрлэгч эхний 10 улсын нэг нь болжээ. Эдгээр улсууд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлсэн байна. Япон, АНУ зэрэг улс орнуудын шууд хөрөнгө оруулалтыг үр дүнтэй ашигласан. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг электрон бараа, компьютерийн эд ангийн үйлдвэрлэл зэрэгт үр дүнтэй ашигласан байна.

Канад, Австрали

Уул уурхайгаас нэлээд хамааралтай боловч уул уурхайн ашиг, орлогоо бусад салбаруудын хөгжилд дэмжлэг болгон сайтар ашигласан. Далайн гарц, зах зээлийн том багтаамжаа сайн ашигласан. Аж үйлдвэр, аялал жуулчлал, банк санхүүгийн үйлчилгээ эдийн засагт нь голлох байр суурь эзэлдэг онцлогтой. Татвар, төлбөрийн уян хатан бодлого хэрэгжүүлдэг, төсвийн сахилга, хариуцлага өндөртэй зэрэг авч хэрэгжүүлбэл зохих туршлага ихтэй улсууд юм. Австрали улс нь уул уурхайдаа хүний оролцоог багасгахад чиглэгдсэн техник, технологи, автоматжуулалт нэвтрүүлэхээр ажиллаж байгаа нь хүн ам цөөнтэй манай улсад ч анхаарвал зохих асуудал юм. Автоматжуулалт нь бүтээмжийг хэдэн арав дахин нэмэгдүүлж, экспортыг үлэмж хэмжээгээр өсгөдөг аж. Австрали одоогоор эрчим хүчнийхээ хэрэгцээний 80 хувийг нүүрс шатаах замаар хангадаг бол 100 хувь сэргээгдэх эрчим хүчээр хангах зорилт тавьж, түүндээ уул уурхай, эрдэс баялгийн түүхий эдээ ашиглахаар зорьж байна. Уул уурхайгаас орох орлогоо гол салбар болох боловсрол болон хөдөө аж ахуйн салбартаа шингээдэг. Мөн мэдлэг, боловсрол, ноу-хаугаа хөгжүүлэх, экспортлоход илүү анхаарч байна. Байгалийн баялгийн нөөц дуусвал яах вэ

гэдгээ одооноос төлөвлөж, тооцоолж байна. Metallургийн үйлдвэрлэлээ металл ашигт малтмалын олборлолттой зэрэгцүүлэн хөгжүүлж, өнгөт болон хар металлургийн үйлдвэр эрчимтэй хөгжиж байна. Мөн уул уурхайн ашиг, орлогын багагүй хэсгийг дэд бүтцээ хөгжүүлэхэд зарцуулдаг ажээ.

Чили

Нутаг дэвсгэр нь 4200 гаруй км сунаж тогтсон, 17.5 сая хүн амтай. Байгалийн баялгаараа Латин Америкад төдийгүй дэлхийд дээгүүр ордог. Уул уурхайн бодлого нь харьцангуй тогтвортой хэрэгжиж ирсэн. Одоо 2018-2050 онд баримтлах үндэсний уул уурхайн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Засгийн газраас нь хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Хөрөнгө оруулалтын менежментийн газар байгуулахаар шийдвэрлэж, уул уурхайн 50 тэрбум ам.доллараас дээш үнийн дүнтэй төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх бодлого баримтлаж байна. Зэсээс гадна литийн дэлхийн нийт нөөцийн 52% нь энэ улсад байдаг мэдээ байна. Иймээс литийн олборлолт боловсруулалтанд анхаарал хандуулж байна.

Перу

Зэс, цайр, мөнгөний нөөцөөрөө дэлхийд дээгүүр ордог. Дэлхийн зэс үйлдвэрлэлийн 12%-ийг эзэлж байна. Уул уурхайн хөрөнгө оруулалтын хууль нь хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлдэг, энэ байдлаар дэлхийд 19-р байрт орж байна. Гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй бодлого баримталдаг. Төвлөрлийг сааруулах асуудал энэ улсад бас л их тулгамдасан асуудлын нэг болдог. Хүн амын 1/3 нь нийслэл Лимад төвлөрдөг. 70-аад онд 3.5 сая хүнтэй байсан бол одоо 10 саяд хүрчээ. Төвлөрлийг сааруулах үүднээс байгалийн баялгийн орлогын хуваарилалтыг бүс нутагруу чиглүүлэх, эрх мэдэл, санхүүгийн эх үүсвэрийг орон нутагт шилжүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Нэг хэсэг олон зуун уурхай хаалт хийлгүй орхих үзэгдэл даамжирсан учир 2003 онд Уул уурхайн хаалтын хууль гаргасан. Уул уурхайн үйлдвэрлэлд концессийн гэрээг нэлээд хэмжээгээр ашиглаж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх бодлого баримтлаж байна. Перугийн хөрөнгө оруулалтын агентлагаас 2018 онд ашигт малтмалын 15 тендер зарлахаар мэдэгдсэн байна.

Аргентин

Аргентин улс 44 сая хүн амтай, 23 мужтай. Засгийн газар нь 2017 онд мужуудтайгаа уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар “Холбооны уул уурхайн

шинэ гэрээ” гэсэн нэртэй гэрээ байгуулж, хөрөнгө оруулалт татах шинэ хууль батлахаар ажиллаж байна. Уул уурхайн сайд нь 2018 оны РДАС-ийн хурал дээр “Бид улсаараа нэг шийдэлд хүрч, уул уурхайгаа хөгжүүлэх чиглэлд санал нэгдсэн” хэмээн илтгэлдээ дурьдсан байна. Литийн нөөцөөрөө хөрөнгө оруулагчдын анхаарлыг нэлээд татах болсон. Жилд 40000 тонн литий олборлож байгаа нь дэлхийн олборлолтын 12%-ийг эзэлж байгаа аж. Хөрөнгө оруулалт, хайгуул, уул уурхайн үйл ажиллагаанд таатай бус нөлөөг үзүүлдэг хуулиудаа эргэж харах, нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг бүсчлэн хөгжүүлэх бодлогын үндэслэл

Манай улсад одоо идэвхитэй ажиллаж байгаа уурхай, хүнд үйлдвэрүүд болон бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуул олборлолт хийж буй газрын тосны талбай, мөн хайгуулын ажил идэвхитэй гүйцэтгэж байгаа ба олборлолтонд бэлтгэж буй цацраг идэвхит ашигт малтмалын талбайн байршлаас харахад эдийн засгийн төвийн бүсэд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын уурхай, үйлдвэрийн үйл ажиллагаа өргөн хүрээтэй, олон чиглэлээр өрнөж байгаа бол зүүн бүсэд холимог металл, нүүрс, хайлуур жонш, төмрийн хүдрийн цөөн бус уурхай, үйлдвэр ажиллаж байгаагийн дээр нийт стратегийн ордын бараг 1/3 нь энэ бүсэд байршиж байна. Мөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн 52.4%, хайгуулын тусгай зөвшөөрлийн 41.9% нь төвийн бүсэд ногдож байгаа бол ашиглалтын тусгай зөвшөөрлийн 14.2%, хайгуулын тусгай зөвшөөрлийн 11.0% нь зүүн бүсэд хамаарч байна. Зэс хайлуулах болон газрын тос боловсруулах үйлдвэрүүд ч төвийн бүсэд баригдахаар болж, эхний ажлууд хийгдэж эхлээд байна.

Эдийн засгийн баруун ба хангайн бүсэд Баянхонгор орчмын алтны хэдэн уурхайг эс тооцвол аймаг бүрт орон нутгийн нүүрсний уурхайнуудаас гадна ганц нэг металл ашигт малтмалын уурхай ажиллаж байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн 14.1%, хайгуулын тусгай зөвшөөрлийн 10.9% нь хангайн бүсэд ногдож байгаа бол ашиглалтын тусгай зөвшөөрлийн 9.4%, хайгуулын тусгай зөвшөөрлийн 28.3% нь баруун бүсэд байршиж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын одоогийн байдал нь нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд бус тархалттай, үйл ажиллагаа нь эрчимтэй биш,

томхон хүчин чадлаар ажиллаж байгаа цөөн тооны төслүүдийг эс тооцвол улсын эдийн засаг, нийгмийн амьдралд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлж байгаа төсөл ховор байна.

Нөгөө талаар улс орны дэд бүтцийн хөгжил сул, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ бага, хүн амын 40 шахам хувь нь ядуу, гадаад, дотоодын өр, зээл ихтэй байгаа зэрэг нь улсын эдийн засгийг ойрын болон дунд хугацаанд эрчимтэй хөгжүүлэх, ДНБ-ний хэмжээ, экспортыг нэмэгдүүлэх, орлогыг хуримтлуулж, хөрөнгө оруулалт хийх, стратегийн салбаруудад дэмжлэг үзүүлэх шаардлага байсаар байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын бүсүүд

Ойрын хугацаанд эрчимтэй хөгжүүлэх бүсүүд

Эрдэнэтийн бүс:

Энэ бүсэд УУБҮ “Эрдэнэт” ажиллаж байгаагаас гадна өнгөт болон хар металлургийн үйлдвэрүүдийн эхлэл, суурь тавигдан хөгжиж байгаагаас гадна хүнд үйлдвэрийн бусад чиглэлээр 10 орчим үйлдвэр ажиллаж байна. “Эрдэнэт” үйлдвэрийг зэс-молибдений хүдрийн нөөцийн хувьд цаашид 50 орчим жил ажиллах боломжтой гэж үздэг. Энд дэд бүтэц, хотжилт сайн хөгжсөн, өнгөт металлургийн үйлдвэрүүд үүсэн хөгжиж буй болон бусад нөөцүүдийн эх үүсвэрийг харгалзан үзэж, жилд 500 мянган тонн зэсийн баяжмал боловсруулах зэс хайлах үйлдвэрийг байгуулах бодит шаардлага байна. Мөн Хөвсгөлийн Бүрэнхааны фосфоритын ордыг ойрын хугацаанд ашиглах, мөн урт хугацаанд Увс-Завханы бүсээс фосфорит үргэлжлүүлэн ашиглах боломжийг харгалзаж фосфоритын баяжмал боловсруулах үйлдвэрийг зайлшгүй барьж ажиллуулах хэрэгцээ байна.

Эрдэнэтийн бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- “Эрдэнэт” УУБҮ (Стратегийн орд) – 1;
- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр – 3;
- Төмөрлөгийн үйлдвэр – 3;
- Машин тоног төхөөрөмжийн үйлдвэр – 1;

- Металл хийцийн үйлдвэр – 2;
- Хий, газрын тос химийн үйлдвэр – 6;
- Ашигт малтмал ашиглалтын 9 тусгай зөвшөөрөл.

Хөвсгөлийн бүс:

Энэ бүсэд фосфоритын томоохон ордууд оршин байдгаас Бүрэнхааны ордыг ойрын хугацаанд ашиглах боломжтой. Цэцэрлэг сумын нутаг дахь Овоотын коксжих нүүрсний ордын нөөцийг ойрын хугацаанд ашиглаж эхлэхээр төсөл хэрэгжүүлэгчид идэвхитэй ажиллаж байна. Мөн Цагаан-Уул сумын нутагт орших Мандалын молибдений орд ашиглалтанд үндсэндээ бэлтгэгдээд байна. Энэ хоёр ордыг түшиглэн, нүүрс баяжуулах үйлдвэр, молибдений баяжуулах үйлдвэр зэрэг даацтай үйлдвэрүүд баригдаж олон зуун ажлын байр, дэд бүтцийн сүлжээ бий болно. Эдгээр нь Эрдэнэт-Мөрөн-Овоот-Арц суурийн төмөр замыг барьж байгуулах үндэс нь болж байгаа юм. Энэ бүсэд Могойн гол, Овоот, Нүүрстэй, Жилчигбулагийн нүүрсний ордуудыг түшиглэх ДЦС, коксын үйлдвэрүүдийг байгуулан экспорт, ажлын байрны эх үүсвэрийг нэмэгдүүлэх бололцоотой. Мөн энэ бүсэд ашигт малтмал ашиглалтын 20, хайгуулын 10 тусгай зөвшөөрөл байгаа нь уул уурхайн хөгжлийн ирээдүйг харуулж байна. Хөвсгөлийн бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Бүрэнхааны фосфоритын стратегийн орд;
- Онгилог нуурын фосфоритын орд;
- Манхан уулын фосфоритын орд;
- Могойн голын чулуун нүүрсний орд;
- Овоотын коксжих нүүрсний орд;
- Нүүрстэйн нүүрсний орд;



Зураг 1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын бүсүүд

- Жилчигбулагийн нүүрсний орд;
- Мандалын молибдений орд;
- Ашигт малтмалын ашиглалтын 20-иод тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 10-аад тусгай зөвшөөрөл.

Сэлэнгэ-Дарханы бүс:

Сэлэнгэ-Дарханы бүс нь уул уурхай, хүнд үйлдвэр эрчимтэй хөгжиж байгаа бүс юм. Энэ бүсэд төмрийн хүдрийн гол том ордуудаас гадна нүүрсний томоохон ордууд, олон тооны алт, холимог металлын ордууд оршдогийн дотор стратегийн 2, стратегийн нөөц 3 орд байдаг. Хүнд үйлдвэрийн 10 гаруй үйлдвэр, барилгын материалын томоохон үйлдвэрүүд идэвхитэй ажиллаж байна. Энэ бүсэд ойрын хугацаанд хар металлургийн үйлдвэр, кокс-химийн, төмөрлөгийн, барилгын материалын үйлдвэрүүд эрчимтэй хөгжих дэд бүтэц, ажиллах хүчний болон бусад нөөцийн бодит бололцоотой. Энэ бүсэд ашигт малтмал ашиглалтын 200 гаруй, хайгуулын 60 гаруй тусгай зөвшөөрөл байна.

Сэлэнгэ-Дарханы уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Төмөртэйн төмрийн хүдрийн стратегийн орд;
- Гацууртын алтны хүдрийн стратегийн орд;
- Төмөр толгойн төмрийн хүдрийн стратегийн нөөц орд;
- Нарантолгойн алтны хүдрийн стратегийн нөөц орд;
- Цагаандавааны гянт болдын стратегийн нөөц орд;
- Шарын голын хүрэн нүүрсний орд;
- Жаргалантын хүрэн нүүрсний орд;
- Хөтөлийн цементийн үйлдвэр;
- Шохойн чулууны 3 уурхай;
- Шороон ордын алтны 29 уурхай;
- Холимог металлын 1 орд;
- Төмрийн хүдрийн 4 уурхай;
- Төмөрлөгийн үйлдвэр – 5;
- Машин тоног төхөөрөмжийн үйлдвэр – 1;
- Металл хийцийн үйлдвэр -1;
- Хий, газрын тос, химийн үйлдвэр – 2;
- Барилгын материалын үйлдвэр – 1;
- Ашигт малтмал ашиглалтын 200 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 60 гаруй тусгай зөвшөөрөл.

Улаанбаатар – Төв аймгийн бүс:

Энэ бүсэд нүүрсний стратегийн болон нөөц ордын нөөцийг ашиглаж буй олон тооны уурхай ажиллаж байгаагийн зэрэгцээ хүрэн нүүрс, шохойн чулуу, хайлуур жонш, алт, өнгөт металлын олон тооны ордууд байрладаг. Хүнд үйлдвэрийн 28, барилгын материалын 2 үйлдвэр идэвхитэй ажиллаж байна. Энэ бүсэд ашигт малтмал ашиглалтын 480 гаруй, 430 гаруй тусгай зөвшөөрөл ногдож байгаа нь энэ бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн ирээдүй юм.

Улаанбаатар-Төв аймгийн бүсийн одоо ба ирээдүй:

- Багануурын хүрэн нүүрсний стратегийн орд;
- Налайхын чулуун нүүрсний стратегийн нөөц орд;
- Цайдам нуурын хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Төгрөг нуурын хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;

- Жанчивлангийн цагаан тугалганы стратегийн нөөц орд;
- Цагаан толгойн хүрэн нүүрсний орд;
- Шанаганы хүрэн нүүрсний орд;
- Өнжүүлийн хүрэн нүүрсний орд;
- Шохойн чулууны 8 уурхай;
- Хайлуур жоншны уурхай – 1;
- Жонш баяжуулах үйлдвэр – 2;
- Шороон ордын алтны 13 уурхай;
- Гянт болдын уурхай - 1;
- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр – 1;
- Машин, тоног төхөөрөмжийн үйлдвэр – 15;
- Металл хийцийн үйлдвэр – 6;
- Хий, газрын тос, химийн үйлдвэр – 6;
- Барилгын материалын үйлдвэр – 2;
- Ашигт малтмалын ашиглалтын 480 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 430 гаруй тусгай зөвшөөрөл.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн тусгай бүсүүд

Төв аймгийн Заамарын район болон Баянхонгор аймагт одоо ажиллаж байгаа нийт алтны уурхайн дийлэнхи нь байгаа бөгөөд маш олон тооны тусгай зөвшөөрлүүд байна. Алт нь улсын валютын нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг, өндөр ач холбогдол бүхий ашигт малтмал учраас тусгай бүсүүдийг тогтоож, тусгайлан хөгжүүлэх шаардлагатай гэж үзлээ. Эдгээр бүсүүдэд алт олборлолтын дэвшилтэт, шинэ технологи нэвтрүүлэх, металл авалтын хэмжээг өндөр түвшинд хүргэх, хүн ам, нийгэм, байгаль орчны тусгайлсан бодлого хэрэгжүүлэх шаардлага бий.

Тусгай бүсүүдийн одоо ба ирээдүй:

1. Заамарын алтны бүс:

- Алтны үндсэн ордын уурхай 3;
- Шороон ордын алтны уурхай 50;
- Галтын хүрэн нүүрсний уурхай;
- Алтны ашиглалтын 30 гаруй тусгай зөвшөөрөл (ажиллаж буйгаас гадна);
- Алтны хайгуулын 10 гаруй тусгай зөвшөөрөл.

2. Баянхонгорын алтны бүс:

- Алтны үндсэн ордын уурхай 2;
- Шороон ордын алтны уурхай 14;
- Зэсийн 1 уурхай;
- Хүрэн нүүрсний уурхай 1;
- Алтны ашиглалтын 50 тусгай зөвшөөрөл (ажиллаж буйгаас гадна);
- Ашигт малтмалын хайгуулын 80 гаруй тусгай зөвшөөрөл.

Дундговь – Говьсүмбэрийн бүс:

Энэ бүсэд стратегийн 1 орд, стратегийн 7 нөөц орд, чулуун ба хүрэн нүүрсний хэд хэдэн орд, хайлуур жоншны ажиллаж байгаа 38 уурхай, литий, манган зэрэг өндөр ач холбогдол бүхий металлын уурхайнууд, холимог металлын, мөнгөний, төмрийн хүдрийн уурхайнууд, цементийн үйлдвэр, шохойн чулууны уурхай, газрын тосны 3 орд, цацраг идэвхит ашигт малтмалын 3 талбай зэргийг багтааснаас гадна дэд бүтэц сайн хөгжсөн маш хүчтэй бүс. Энэ бүсэд Хэнтийн Дархан, Дорноговийн Иххэт, айраг, Даланжаргалан сумдын нутгийг хамруулан авч үзсэн. Дундговь-Говьсүмбэрийн бүсэд жилд 1-1.7 сая тонн зэсийн баяжмал боловсруулах Бор-Өндөрийн зэс хайлуулах үйлдвэр төлөвлөгдсөн, мөн Бор-Өндөрийн хайлуур жоншны УУБҮ-ийг түшиглүүлэн хайлуур жоншны баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах боломжтой. Тус бүсэд 100 гаруй ашиглалтын, 120 гаруй хайгуулын тусгай зөвшөөрөл хамрагдаж байна.

Дундговь-Говьсүмбэрийн бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний стратегийн орд;
- Ширээ уулын гөлтгөний стратегийн нөөц орд;
- Баргилтын төмрийн хүдрийн стратегийн нөөц орд;
- Алагтогоогийн нүүрсний стратегийн нөөц орд;
- Хонгорын хайлуур жоншны стратегийн нөөц орд;
- Тэвшийн говийн хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Өвдөг худагийн хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Хөөтийн хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Үнст худагийн хүрэн нүүрсний орд;
- Хашаат худагийн чулуун нүүрсний орд;

- Хайлуур жоншны 38 уурхай;
- Өлзийтийн литийн орд;
- Манганы уурхай – 1;
- Цементийн үйлдвэр – 1;
- Шохойн чулууны уурхай -1;
- Холимог металлын уурхай – 1;
- Төмрийн уурхай 1;
- Мөнгөний уурхай – 1;
- Ураны орд -3;
- Ашигт малтмалын ашиглалтын 100 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 120 гаруй тусгай зөвшөөрөл.

Өмнөговь – Дорноговийн бүс:

Энэ бүсэд стратегийн стратегийн орд 4, стратегийн нөөц орд 2 харьяалагддаг. Зэсийн томоохон 2 орд, нүүрсний 18 орд хамаарагддагаас гадна алтны 2, хас чулууны 1, холимог металлын 3, болорын 1, газрын тосны 1, гөлтгөнийн 2, цеолит, шохойн чулууны тус бүр 1 уурхай тус тус ажиллаж байна. Мөн ураны 3 талбай, цементийн 1 үйлдвэр харьяалагддаг. Алтанширээ суманд газрын тосны (жилд 1сая 500 мянган тонн түүхий газрын тос) боловсруулах үйлдвэр баригдаж байна. Энэ бүс нь манай улсын уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийг тэргүүлж байгаа бүс. Ашиглалтын 270 гаруй, хайгуулын 340 гаруй тусгай зөвшөөрлийг хамарч байна.

Өмнөговь-Дорноговийн бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Оюутолгойн зэс-алтны стратегийн орд;
- Тавантолгойн коксжих нүүрсний стратегийн орд;
- Нарийн сухайтын коксжих нүүрсний стратегийн орд;
- Цагаан суваргын зэс-молибдений стратегийн орд;
- Лугийн голын газрын ховор элементийн стратегийн нөөц орд;
- Цагаанцавын цеолитын стратегийн нөөц орд;
- Хармагтайн зэсийн орд;
- Бронз фокус компанийн зэсийн орд;

- Нүүрсний 18 орд;
- Алтан ширээгийн газрын тос боловсруулах үйлдвэр;
- Алтны – 2 уурхай;
- Хас чулууны – 1 уурхай;
- Холимог металлын 3 уурхай;
- Болорын уурхай – 1;
- Зүүнбаянгийн газрын тосны уурхай;
- Гөлтгөнийн – 2 уурхай;
- Ураны 3 уурхай;
- Шохойн чулууны уурхай – 1;
- Цементийн үйлдвэр – 1;
- Цеолитийн уурхай – 1;
- Ашигт малтмал ашиглалтын 270 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 340 гаруй тусгай зөвшөөрөл.

Дорнодын бүс:

Дорнодын бүсэд стратегийн 3 орд, стратегийн нөөц 3 орд харьяалагддаг. Хүрэн нүүрс, цацраг идэвхит ашигт малтмалын ордуудтай, алтны 15, хайлуур жоншны 2, холимог металлын 2, газрын тосны 2 уурхай тус тус идэвхитэй ажиллаж байгаа, дэд бүтэц дунд зэрэг хөгжсөн боловч ойрын хугацаанд дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх бололцоотой. Ойрын хугацаанд цацраг идэвхит ашигт малтмалын уурхай, газрын тос дамжуулах шугам, ДЦС, цайрын өнгөт металлургийн үйлдвэр барих боломжтой. Ашиглалтын 70 гаруй, хайгуулын 100 гаруй тусгай зөвшөөрөлтэй бүс.

Дорнодын бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Мардайн ураны стратегийн орд;
- Гурванбулагийн ураны стратегийн орд;
- Дорнодын ураны стратегийн орд;
- Улааны холимог металлын стратегийн нөөц орд;
- Цавын холимог металлын стратегийн нөөц орд;
- Адуунчулууны хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Баян усны хүрэн нүүрсний орд;
- Ураны 2 орд;

- Шороон ордын алтны 15 уурхай;
- Хайлуур жоншны 2 уурхай;
- Газрын тосны 2 уурхай;
- Ашигт малтмалын ашиглалтын 70 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 100 гаруй тусгай зөвшөөрөл.

Дунд хугацаанд эрчимтэй хөгжүүлэх уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэр технологийн бүсүүд:

Эрдэс баялгийн цөөн бус ордуудын нөөц тогтоогдон түрүүчээсээ ашиглагдаж байгаа боловч дэд бүтцийн хөгжил муу хөгжсөн учир дунд хугацаанд эрчимтэй хөгжүүлэх уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн ангилалд оруулсан 2 бүс байна. Эдгээр бүсүүдэд дунд хугацаанд төмөр зам, цахилгаан эрчим хүчний сүлжээг эрчимтэй хөгжүүлэх болоцоотой, хоёр хөршийн зах зээлд ойр байрлалтай зэрэг үзүүлэлтээр энэ ангиллын бүсэд оруулсан болно.

Увс – Баян-Өлгийн бүс:

Увс-Баян-Өлгийн бүсэд стратегийн 1 орд, стратегийн 4 нөөц орд оршдог, нүүрсний орон нутгийн уурхайнууд, гянт болдын 2 , төмрийн хүдэр, газрын ховор элементийн тус бүр 1, шороон ордын алтны 3 уурхай тус тус ажиллаж байгаа. Өнгөт металлургийн үйлдвэр, ДЦС, кокс-химийн үйлдвэрүүдийг дунд хугацаанд барьж байгуулан ажиллуулах боломжтой. Дэд бүтэц муу хөгжсөн боловч дунд хугацаанд эрчимтэй хөгжүүлэх бололцоотой. Ашиглалтын 70 гаруй, хайгуулын 160 гаруй тусгай зөвшөөрөлтэй.

Увс-Баян-Өлгийн бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Асгатын мөнгөний стратегийн орд;
- Хөх-Адарын зэс, цайрын стратегийн нөөц орд;
- Шүдэн уулын чулуун давсны стратегийн нөөц орд;
- Нүүрст хотгорын чулуун нүүрсний стратегийн нөөц орд;
- Хар тарвагатайн чулуун нүүрсний стратегийн нөөц орд;
- Их мянганы чулуун нүүрсний орд;
- Хүдэнгийн чулуун нүүрсний орд;
- Ногоон нуурын гянт болдын уурхай;

- Ховд голын гянт болдын уурхай;
- Наранбулагийн төмрийн уурхай;
- Шороон ордын алтны 3 уурхай;
- Завханы циркон, газрын ховор элементийн уурхай;
- Ашигт малтмалын ашиглалтын 70 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 160 гаруй тусгай зөвшөөрөл.

Хэнтий – Сүхбаатарын бүс:

Энэ бүсэд стратегийн 1, стратегийн нөөц 4 орд харьяалагддаг, Бор-Өндөрийн зэс хайлуулах үйлдвэр төлөвлөгдөөд байгаа. Төмөртийн Овоогийн цайрын УУБУ, цагаан тугалганы 1, гянтболдын 2, хайлуур жоншны 15, төмрийн хүдрийн 5 уурхай тус тус ажиллаж байгаа. Хүрэн нүүрсний 7, ураны 1 ордтой, дэд бүтэц муу хөгжсөн боловч дунд хугацаанд эрчимтэй хөгжүүлэх боломжтой. Дулааны цахилгаан станц, кокс-химийн үйлдвэр, шатдаг занарын уурхай, занар боловсруулах үйлдвэр байгуулах ирээдүйтэй. Энэ бүсээс Хэнтий аймгийн Дархан сумын нутгийг Дундговь-Говьсүмбэрийн бүсэд оруулан авч үзсэн байгаа. Ашиглалтын 170 гаруй, хайгуулын 180 гаруй тусгай зөвшөөрөл олгогдсон.

Хэнтий-Сүхбаатарын бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Төмөртийн овооны цайрын үйлдвэр (стратегийн орд);
- Бор-Өндөрийн зэс хайлуулах үйлдвэрийн төсөл;
- Мөнгөн өндөрийн холимог металлын стратегийн нөөц орд;
- Чандган талын хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Талбулагийн хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Хөөтийн хүрэн нүүрсний стратегийн нөөц орд;
- Шороон ордын алтны 4 уурхай;
- Цагаантугалганы 1 уурхай;
- Гянтболдын 2 уурхай;
- Хайлуур жоншны 15 уурхай;
- Хүрэн нүүрсний 7 орд;
- Төмрийн хүдрийн 5 уурхай;
- Ураны 1 орд;

- Ашигт малтмалын ашиглалтын 170 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 180 гаруй тусгай зөвшөөрөл.

Урт хугацаанд эрчимтэй хөгжүүлэх уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэр технологийн бүсүүд:

Одоогоор ажиллаж байгаа уурхай, үйлдвэрийн тоо цөөн бөгөөд дэд бүтцийн хөгжил сул, зах зээлээс зайтай байрладаг, геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн үзүүлэлтээр урт хугацаанд эрчимтэй хөгжүүлэх бүсүүдийг тогтоосон.

Увс – Завханы бүс:

Бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Баян-Айрагийн алт, зэсийн уурхай;
- Алтны 2 уурхай;
- Төмөр замын Эрдэнэт-Овоот-Арц суурийн төмөр замын төсөл;
- Ашигт малтмалын ашиглалтын 10 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 80 гаруй тусгай зөвшөөрөл.

Ховд – Говь-Алтайн бүс:


Бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Зээгтийн чулуун нүүрсний стратегийн нөөц орд;
- Чулуун нүүрсний 8 орд;
- Гянт болдын нэг уурхай;
- Шороон ордын алтны 2 уурхай;
- Төмрийн хүдрийн уурхай -1;
- Молибдений уурхай – 1;
- Ашигт малтмалын ашиглалтын 80 гаруй тусгай зөвшөөрөл;
- Ашигт малтмалын хайгуулын 220 гаруй тусгай зөвшөөрөл.

Хангайн бүс:

Бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн одоо ба ирээдүй:

- Тавтын алтны стратегийн нөөц орд;
- Сайхан-Овоогийн нүүрсний стратегийн нөөц орд;



Зураг 7. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил, байршлын нэмүү өртөгийн сүлжээ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг бүсчлэн хөгжүүлэх бодлогын зөвлөмж

Төрөөс эрдэс баялгийн салбарыг ойрын болон дунд, урт хугацаанд эрчимтэй хөгжүүлэх, цаашид тогтвортой хөгжүүлэх, түүний үр дүнд бий болох ашиг, орлогын өсөлтийг улс орны эдийн засгийн хөгжилд үр дүнтэй, өгөөжтэй ашиглах талаар дараах бодлогын зөвлөмжүүдийг санал болгож байна.

Хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд

1. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль болон бодлогын баримт бичгүүдийг төрөл, агуулга, хэрэгжих хугацааг эргэн харж, тодорхой, хэрэгжих бодит боломжтой, тоо хэмжээ, цаг хугацаатай болгон цэгцлэх;
2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг төрийн бодлогоор зохицуулах;
3. Монголын уул уурхайн үйлдвэрлэлийн гол нэр төрөл болох зэс, молибден, төмөр, алт, холимог металл, хайлуур жонш, нүүрс, барилгын материал зэрэг

ашигт малтмалын нөөцийг зүй зохистой ашиглах, эдийн засгийн эргэлтэнд оруулах богино, дунд, урт хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулж, тэдгээрт төрийн бодлогыг тусгаж хэрэгжүүлэх;

4. Тус улсын газар нутаг, газрын хэвлийд оршин байгаа эрдсийн ба бусад баялгийн нөөцийг ашиглах талаар төр болон засгийн газраас гаргасан шийдвэр нь ямар нэг хэсэг бүлэг хүмүүс, төрийн бус байгууллага, аль нэгэн намын эрх ашгаас үл хамааран хэрэгждэг байх тухай заалтыг Монгол улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиудад оруулж мөрдөх;

5. Ашигт малтмалын ордын нөөцийг ТЭЗҮ-ээр тогтоосон хүчин чадлаас нь бага хүчин чадлаар ашиглахыг хориглох тухай заалтыг Ашигт малтмалын тухай хуулинд оруулж мөрдөх;

6. Геолги, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах таатай нөхцөлийг бүрдүүлэх болон хөрөнгө оруулагчийг шалгаруулах тендерийн журмыг боловсруулж хэрэглэх;

7. Эрдэс баялгийн боловсруулаагүй түүхий эдийг экспортлох хэмжээнд үе шаттай хязгаарлалт тогтоох, улмаар боловсруулаагүй түүхий эд экспортлохыг зогсоох тухай заалтыг Ашигт малтмалын тухай хуулинд оруулах;

8. Ашигт малтмалын нөөц ашиглах уурхайг хүчин чадал, хөрөнгө оруулалтынх нь хэмжээгээр том, дунд, жижиг гэж ангилах, ангилал тус бүрт тохирсон бодлого хэрэгжүүлэх талаар “Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт нэмж тусган хэрэгжүүлэх;

9. Өнгөт металл болон төмрийн хүдрийн уул уурхайн баяжуулах үйлдвэрүүдийг дагалдуулан өнгөт ба хар металлургийн үйлдвэрийг барьж байгуулах, улмаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, уул уурхай металлургийн үйлдвэрлэлийг дагалдуулан хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлах;

10. Ойрын болон дунд хугацаанд уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрийн тоог олшруулах, стратегийн ордуудын нөөцийг ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээг бодлогын баримт бичигт нэмж тусган хэрэгжүүлэх;

11. Аль нэг сум, орон нутагт байрлаж буй ашигт малтмалын ордыг ашиглах тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ба сумын засаг захиргааны хоорондын гэрээгээр хамтарсан шинэ компани байгуулах, уг

компанийн нийт хувьцааны тодорхой хэсгийг тухайн ашигт малтмалын нөөцийн үнэ цэнэтэй уялдаатайгаар сум эзэмшдэг байх тухай хууль эрх зүйн орчныг бий болгох;

12. Уул уурхайн үйлдвэрлэлээс орж буй орлогыг хуваарилах, хөгжлийн сан байгуулан ажиллуулах тухай бие даасан хууль боловсруулан мөрдөх;

13. Монгол улсын хэмжээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах тухай буюу хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан ажиллагаа, тохиолдлуудын үр дүнг нэгтгэн гаргаж, алдаа оноог дүгнэх, олон улсын нөхцөл байдал практик ажлуудтай харьцуулан үзэх, ийм төрлийн буюу хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулах чиглэлээр мэргэшсэн баг, түүнийг хянадаг зөвлөгөө өгдөг экспертүүдээс бүрдсэн институцийг бий болгож чадавхижуулах;

14. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалахад хуучнаас нь доргүй орчныг бий болгох хатуу болзлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд гэрээгээр хүлээлгэж, хэрэгжилтийг хянаж хүлээж авдаг тогтолцоог бий болгох;

15. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бүсчилсэн хөгжлийн бодлогын энэхүү судалгааны үр дүнд санал болгож буй уул уурхай хүнд үйлдвэрийн хөгжил байршлын бүсүүдийн хуваарийг ҮХГ, УУХҮЯ-ны хамтарсан шийдвэрээр баталгаажуулж, богино, дунд, урт хугацааны бодлого, зорилго, зорилтуудыг тодорхойлох;

16. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулан эрх бүхий субъектээр батлуулах;

17. “Уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлвэр технологи, тээвэр-логистикийн төв”-үүдийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын бүс бүрт байгуулан ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд

1. Геологи хайгуулын ажлыг нэмэгдүүлэх талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хамтран ажиллах, тэдний ажлын нөхцөл байдал, т.з эдэмшигчийн үүргээ хэрхэн биелүүлж байгаад аттестатчилал хийх;

2. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлээс орох орлогыг 2019-2024 онд 2 дахин, 2025-2035 онд 4 дахин, 2036-2050 онд 6 дахин нэмэгдүүлэх зорилт тавин хэрэгжүүлэх;
3. Заамар, Баянхонгорын алтны бүсүүдийн үлдэгдэл нөөцийг тооцоолж үзэх, шороон ордын алтны уурхайнуудын металл авалтын түвшинд аттестатчилал хийж, металл авалтын доод хэмжээг заан хэрэгжүүлэх, металл авалт өндөртэй техник технологи хэрэглэх шаардлага бий болгож, хэрэгжүүлэх;
4. Улаанбаатар хотод алт цэвэршүүлэх үйлдвэр (жилд 15 тонн алт) байгуулах;
5. Стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Асгат, Бүрэнхаан, Цагаан суваргын мөнгө, фосфор, зэс-молибдений ордуудыг ойрын хугацаанд ашиглах, Дорнод аймгийн Дашбалбар сумын нутаг дахь ураны 3 ордоос аль нэгийг нь мэргэжлийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн туслалцаатайгаар сонгож олборлолтын ажлыг мөн ойрын хугацаанд (2019-2024 онд) эхлүүлэх;
6. Стратегийн ордын тоонд оруулахаар нэр нь дурьдагдсан ордуудаас Нарантолгойн алт, Улаан, Цавын холимог металл, Хөх-Адарын зэс-цайр, Лугийн голын газрын ховор элементийн ордуудыг стратегийн ордод оруулах шийдвэр гаргах, Нарантолгой, Улаан, Цавын алт болон холимог металлын уурхайнуудын үйлдвэрлэл, экспорт, хөрөнгө, хувьцааны талаарх мэдээллүүдийг олон нийтэд ил болгох;
7. Хөх-Адар (зэс, молибден), Лугийн гол (газрын ховор элемент)-ын ордуудын нөөцийг ашиглаж эхлэх арга хэмжээг 2024 оны дотор авах;
8. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул сумын нутаг дахь Овоотын коксжих нүүрсний орд, Мандалын молибдений ордын нөөцийг ашиглах төслийг т.з эзэмшигч нартай хамтран 2019-2024 онд хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;
9. Цацраг идэвхит ашигт малтмалын Дулаан уул, Зөөвч овоо, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт зэрэг ордын нөөцийг ашиглах талаар арга хэмжээ авах, тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай ажиллах, энэ чиглэлийн гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжуудыг судлах;
10. Дээрхи арга хэмжээнүүдтэй уялдуулан баруун аймгуудыг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох, Тавантолгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээ хүрэн, Зүүнбаян-Ханги, Сайншанд-Цагаансуварга-Тавантолгой, Эрдэнэт-Мөрөн-Овоот-Арц суурийн төмөр замыг 2019-2024 онд, Сайншанд-Баруун-Урт-

Хөөт-Баянтүмэн, Тавантолгой-Даланзадгад-Нарийн сухайтын төмөр замуудыг 2035 гэхэд барьж дуусгах.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлын хүрээнд

1. Зэс хайлуулах үйлдвэрийг Эрдэнэт хотод (жилд 500 мянган тонн баяжмал) болон Бор-Өндөрийн (жилд 1-1.7 сая тонн баяжмал) үйлдвэрлэлийн тосгонд байгуулах төслүүдийг 2019-2024 онд хэрэгжүүлэх;
2. Эрдэнэтийн зэс хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн хүчлийг ашиглан фосфоритын баяжмал боловсруулах (жилд 3 сая тонн баяжмал боловсруулах) үйлдвэрийг Эрдэнэт хотод байгуулах төслийг хэрэгжүүлэх;
3. Бор-Өндөрийн зэс хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн хүчлийг ашиглан хайлуур жоншны баяжмал боловсруулах (жилд 100-150 мян.тн баяжмал) үйлдвэрийг байгуулж, хайлуурын хүчил, гөлтгөнө, креолит зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
4. Чойбалсанд Төмөртийн овоо, Улаан, Цавын УУБҮ-ээс гарах баяжмал боловсруулах цайрын өнгөт металлургийн (жилд 150 мянган тонн баяжмал) үйлдвэрийг байгуулах;
5. Асгатын мөнгөний ордыг түшиглүүлэн, УУБҮ, мөнгөний металлургийн үйлдвэр (жилд 100 тонн баяжмал боловсруулах) байгуулах арга хэмжээг дунд хугацаанд т.з эзэмшигчтэй нь хамтран хэрэгжүүлэх;
6. Дархан (6-7 сая тн баяжмал), Сайншанд (1 сая тн баяжмал), Говь-Алтайн Таяннуурт (1 сая тн баяжмал) гангийн үйлдвэр байгуулж, төмөр бэлдцүүд үйлдвэрлэх;
7. Хөвсгөлийн Овоотоос баяжуулсан нүүрс, кокс, Мандалаас молибдений баяжмал үйлдвэрлэн гаргах;
8. Увс-Баян-Өлгий, Ховд-Говь-Алтай, Хөвсгөлийн бүсүүдэд 60 МВт-аас багагүй хүчин чадалтай, Дундговь-Сайншанд, Өмнөговь-Дорноговь, Хэнтий-Сүхбаатар, Дорнодын бүсүүдэд өндөр хүчин чадалтай ДЦС-ууд барьж, цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэн хэрэглэх;
9. Коксжих чулуун нүүрсний уурхай бүрийн дэргэд коксын үйлдвэр байгуулж, коксыг экспортлох ба хий, шингэн түлш, давирхай зэргийг дотооддоо ашиглах;

8. Бага-нуур, Адуунчулуун, Шивээ Овоогийн уурхайг түшиглүүлэн боловсруулж буй нүүрс шингэрүүлэх төслүүдийн үр дүнг гаргаж, хэрэгжих боломжтойг нь эхлүүлэх;

9. Хүрэн нүүрсний уурхай бүрийн дэргэд био бордооны үйлдвэрүүд байгуулах ажлыг 2019-2024 онд хэрэгжүүлэх;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн үйл ажиллагааны зохицуулалтын хүрээнд

1. “Уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэр, технологи, тээвэр-логистикийн төв” (УУХҮ-ҮТТЛТ)-ийг Улаангом, Улиастай, Мөрөн, Алтай, Баянхонгор, Заамар (сумын төв), Цэцэрлэг, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар, Чойр, Даланзадгад, Сайншанд, Баруун-Урт, Дорнод хотуудад байгуулах;

2. Тухайн бүс нутгийн уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, хэтийн төлөв, хөгжил байршил, тээвэр-логистикийн асуудлыг эдгээр төвүүд хариуцан зохицуулдаг байх;

3. Ярант, Цагаан нуур, Арц суурь, Сүхбаатар, Эрээнцав, Сүмбэр, Бичигт, Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн, Бургастайн боомтууд болон Дархан, Улаанбаатар, Чойр, Айраг, Даланжаргалан, Сайншанд, Ханбогд, Цагаан суварга, Тавантолгой, Даланзадгад, Нарийн сухайт, Баруун-Урт, Хөөт, Баянтүмэн (Чойбалсан), Тамсагбулаг, Шинэжинст, Чандмань, Хөшөөт, Алтай, Дөрвөлжин, Ургамал, Цагаанхайрхан, Улаангомын өртөөнүүд дээр дамжин өнгөрөх ачаа эргэлт, ачааны төрөл, ачих буулгах хүчин чадалд нь тохирсон терминалуудыг орчин үеийн стандартад нийцүүлэн тухайн үед нь барьж байгуулан ашиглах.

Ажиллах хүчний хангалт, зохицуулалтын хүрээнд

1. Уул уурхай, өнгөт ба хар металлурги, кокс-хими технологийн үйлдвэр, төмөр замын оператор, техникч, машинч, засварчин, замчин, хүнд даацын автомашины жолооч, зарим тохиолдолд, нефтийн үйлдвэрийн операторууд зэрэг мэргэжлийн мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх мэргэжил сургалтын төвүүдийг эдийн засгийн баруун, хангайн, төвийн, зүүн болон Улаанбаатарын бүсүүдэд байгуулан ажиллуулах;

2. Уул уурхай, өнгөт ба хар металлурги, кокс-хими технологи, газрын тос боловсруулах, цацраг идэвхит ашигт малтмал олборлох үйлдвэрүүдийн инженер техникийн ажилтнуудыг тодорхой шалгаруулалт, гэрээний үндсэн дээр сонгон авч гадаад улс орнуудад суралцуулах, зардалд нь уул уурхайгаас орж буй орлогоос боловсролын салбарт ногдох хэсгээс ашиглах;
3. Нэмүү өртөг шингээдэг болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрийн ажиллагсадыг дадлагажуулах, сургахад зориулан өндөр чадвартай гадаад мэргэжилтнүүдийг урьж, үйлдвэр дээр нь гэрээгээр ажиллуулах.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн хотхон, суурин байгуулах хүрээнд

Ойрын ба дунд, урт хугацаанд уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн дэд төвүүд болгон хөгжүүлэхэд чиглүүлж дор дурьдсан сум, орон нутаг байршилд, 5-15 мянган хүн амтай хотхон, суурин байгуулж, хүн амын төвлөрлийг сааруулахад зохих хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Ойрын нугацаанд:

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Төв аймгийн Заамар, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурван тэс, Дорноговь аймгийн Мандах, Даланжаргалан, Хэнтийн Бор-Өндөр, Дорнодын Дашбалбар сумуудад 10-15 мянган хүн амтай хотхон, суурин байгуулах.

Дунд хугацаанд:

Баян-Өлгийн Асгат, Увс аймгийн Бөхмөрөн, Хэнтийн Бэрх зэрэг сум байршилд 5-10 мянган хүн амтай хотхон суурин байгуулах.

Урт хугацаанд:

Говь-Алтайн Төгрөг, Баянхонгорын Шинэжинст, Өвөрхангайн Баянтээг зэрэг сум, байршилд 5-10 мянган хүн амтай хотхон суурин байгуулах.

Хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогын хүрээнд

1. Хөрөнгө оруулалтын менежментийн газар байгуулан ажиллуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын үр өгөөж, ашиглалтын менежментийг оновчтой гүйцэтгэх;
2. Уул уурхайн үйлдвэрлэлээс орж буй орлогын дийлэнхи хувийг ирээдүйн хөрөнгө оруулалтад зориулсан санд төвлөрүүлэх, орлогын үлдсэн хувийг боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбаруудын хөгжилд зарцуулах;

3. Төвлөрлийг сааруулах үүднээс байгалийн баялгийн орлогын хуваарилалтыг бүс нутагруу чиглүүлэх, эрх мэдэл, санхүүгийн эх үүсвэрийг орон нутагт шилжүүлэх бодлого баримтлах.

Дүгнэлт

1. Өнөөгийн байдлаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил нь урсгалаараа, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санаачлагыг даган зөнгөөрөө гэлдэрч байна.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хэмжээг ойрын, дунд, урт хугацаанд шаталсан байдлаар эрс нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн үйл явц улс төрөөс хэт их хамааралтай, салбарын яам бодлогоо хэрэгжүүлж чадахгүй байна.

4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжилд төр шийдвэртэй, үүргийнхээ дагуу оролцож, шийдвэр гаргаж, хэрэгжүүлж чадахгүй байна.

5. Эрдэс баялгийн салбарын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигт дээр дурьдсан зөвлөмжийг тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

6. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын менежментийг хэрэгжүүлдэг институцийг бий болгож, ажиллуулах хэрэгтэй байна.

7. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөгжил нь төвлөрлийг сааруулахад чухал нөлөө үзүүлдэг хэрэгсэл мөн тул энэ хэрэгслийг ухаалаг үр дүнтэй ашиглахад хөгжлийн бодлогын байгууллагаас тусгайлсан бодлого, хөтөлбөр боловсруулж, УУХҮЯ, БХБЯ-тай хамтран хэрэгжүүлэх асуудал чухал байна.

8. Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийг бүсчлэн хөгжүүлэх бодлогын хувилбарыг *нэгдүгээрт*: уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын одоо ажиллаж байгаа үйлдвэр уурхайн байршил, хэтийн төлөв, *хоёрдугаарт*: Монгол улсын нутаг дэвсгэрийн дэд бүтцийн өнөөгийн болон ойрын, дунд ба урт хугацааны хөгжлийн төлөв байдал, *гуравдугаарт*: 2018 оны 7 дугаар сарын байдлаар эдийн засгийн бүсүүдийн нутаг дэвсгэрт олгогдоод байгаа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо зэрэг тодорхой хүчин зүйлүүдийг үндэслэн, салбарын хөгжлийн орц, гарц, нэмүү өртөгийн сүлжээний хамт боловсруулж энэхүү тайланд тусгав.

9. “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого” боловсруулах ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ҮХГ/062 тоот гэрээний Хавсралт 1.-д тусгасан ажлын даалгаварын дагуу судалгааны ажлыг гүйцэтгэх явцад үе шатны 3 тайлан боловсруулагдсан бөгөөд судалгааны үе шат бүрийн ажлын даалгаварын заалт бүрийн дагуу уг ажлыг гүйцэтгэж эдгээр тайлангуудад тусгасан болно.

Ашигласан материалын жагсаалт

1. МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
2. МУ-ын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;
3. МУ-ын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого;
4. МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
5. МУ-ын ЗГ-ын Гурван тулгуурт хөгжлийн бодлого;
6. Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах бодлого;
7. МУ-ыг үйлдвэржүүлэх хөтөлбөр;
8. “Алт-2” үндэсний хөтөлбөр;
9. Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого;
10. Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого;
11. Төрөөс цацраг идэвхт ашигт малтмалын болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого;
12. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого;
13. Хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр;
14. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
15. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
16. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам;
17. Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангууд;
18. Эрдэс баялгийн статистик мэдээнүүд 2017, 2018 ҮИ сар;
19. КОИСА-ийн МУ-ын уул уурхайн салбарын судалгааны материалууд